



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 105

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө шилжүүлэх, акталж данснаас хасах, худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 171,540,141.98 (нэг зуун далан нэгэн сая таван зуун дөчин мянга нэг зуун дөчин нэгэн төгрөг ерэн найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, 102,270,350.53 (нэг зуун хоёр сая хоёр зуун далан мянга гурван зуун тавин төгрөг тавин гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгийг Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагуудад 1 дүгээр хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Цагдаагийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт 215,644,686.90 (хоёр зуун арван таван сая зургаан зуун дөчин дөрвөн мянга зургаан зуун наян зургаан төгрөг ерэн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 215,408,436.90 (хоёр зуун арван таван сая дөрвөн зуун найман мянга дөрвөн зуун гучин зургаан төгрөг ерэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 2 дугаар хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

3. Цагдаагийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 21,854,000.00 (хорин нэгэн сая найман зуун тавин дөрвөн мянган) төгрөгийн балансын үнэ бүхий суудлын автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг 3 дугаар хавсралтад заасны дагуу тогтоосугай.



4. Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн комиссар Р.Чингист дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

4.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, шилжүүлэх, худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

4.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

4.3. Энэ тогтоолын биелэлтийг 2017 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.НЯМ-ОСОР
ЗАХИРГАА
ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА  Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2016 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
 ... дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВТОБААЗЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
 НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Д/д	Хөрөнгийн нэр	Авто машинны улсын дугаар	Ашиглалтад орсон он сар өдөр	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Хьюндай Акцент	34-98 УБР	05.06.02	3,400,000.00	3,400,000.00	-	1,000,000.00
2	Хьюндай Акцент	04-34 УБЦ	06.06.06	4,454,000.00	4,454,000.00	-	1,000,000.00
3	Хьюндай соната 3	02-97 УБУ	06.11.28	5,000,000.00	5,000,000.00	-	1,300,000.00
4	Хьюндай Грейс	02-73 УБУ	05.12.30	4,500,000.00	4,500,000.00	-	1,000,000.00
5	Хьюндай Грейс	93-26 УБА	05.12.30	4,500,000.00	4,500,000.00	-	1,000,000.00
	Дүн			21,854,000.00	21,854,000.00	-	5,300,000.00
				(Хорин нэгэн сая найман зуун тавин дөрвөн мянган төгрөг)	(Хорин нэгэн сая найман зуун тавин дөрвөн мянган төгрөг)		(Таван сая гурван зуун мянган төгрөг)

-----000-----